



MNAS AC11

МОНГОЛ УЛСЫН
ИТГЭМЖЛЭЛИЙН
ТОГТОЛЦОО

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БАТАЛГААЖУУЛАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН ИТГЭМЖЛЭЛИЙН ШАЛГУУР

Нэгдсэн үндэсний гудамж 5/1, 3Г-ын II байр

Улаанбаатар 15160, Монгол Улс

Утас: (976) 77073689

Цахим хуудас: www.mnas.gov.mn

Цахим шуудан: info@mnas.gov.mn

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

ХЭВЛЭСЭН ОГНОО:
18.12.2015

ӨӨРЧЛӨЛТ NO: 03
ӨӨРЧЛӨЛТИЙН ОГНОО: 25.04.2024

0 Оршил

Аж үйлдвэрийн салбар, менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын хэрэгцээ шаардлагыг хангах зорилгоор Монгол Улсын засгийн газар болон Үндэсний итгэмжлэлийн төв хамтарч Чанарын менежментийн тогтолцоо (ЧМТ), Байгаль орчны менежментийн тогтолцоо (БОМТ) болон бусад менежментийн тогтолцооны баталгаажуулалтын итгэмжлэлийн тогтолцоог бий болгохоор ажиллаж байгаа билээ.

MNAS-ийн баталсан Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны эхний шалгуурыг Монгол Улсад явагдаж буй баталгаажуулалтын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, гадаад улс болон бүс нутаг, олон улсын гэрээнд нэгдэх зорилгоор ISO/IEC 17021, ISO/TS 22003:2013 стандартын дагуу боловсруулсан. Итгэмжлэлийн шалгуурыг IAF/APAC-аас шинээр хэвлэгдсэн стандарт, заавал дагаж мөрдөх баримт бичгийн лавлагааг тусгах зорилгоор тогтмол шинэчилдэг.

1 Хамрах хүрээ

Энэхүү баримт бичиг нь Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо (ХАБМТ)-ны баталгаажуулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хөндлөнгийн байгууллагыг MNAS-аас Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын үйл ажиллагааг явуулах чадвартай, найдвартай гэж үнэлэхэд тавигдах шаардлагыг тодорхойлно.

2 Шалгуур

- Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалт хийх итгэмжлэл хүссэн Баталгаажуулалтын байгууллага нь ISO/IEC 17021 болон ISO 22003-1 стандартуудад заасан шаардлагуудыг хангах үүрэгтэй.
- Баталгаажуулалтын тогтолцоог ISO 22000 стандартад заасан Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны шаардлага эсвэл MNAS-ийн баталсан бусад эн тэнцүү баримт бичгийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг нь үнэлнэ.
- ISO/IEC 17021 болон ISO 22003-1 стандартын хувь, хуулбарыг Монгол Улсын Стандарт, хэмжил зүйн газар (СХЗГ)-аас авч болно.

Тайлбар: MNAS нь ISO 17021 ба/эсвэл ISO 22003-1 стандартын дагуу IAF/APAC-ын заавал дагаж мөрдөх баримт бичиг шинэчлэгдэх бүрт тус итгэмжлэлийн шалгуурын нэг хэсэг болгон нийцүүлнэ.

3 ISO 22003-1 стандартын шаардлагын удирдамж

MNAS нь ISO/IEC 17021 стандартын шаардлага болон IAF-н заавал мөрдөх баримт бичгүүдийг нэмэлт шалгуурын баримт бичгээр ашигладаг. Итгэмжлэлийн шалгуурын талаар тодруулга хэрэгтэй бол MNAS нэмэлт тайлбар өгнө.

Тайлбар: IAF-н заавал мөрдөх баримт бичгийг IAF цахим хуудаснаас англи, MNAS цахим хуудаснаас монгол хэлээр тус тус үнэгүй татаж авах боломжтой.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC11	Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо:18.12.2015	Өөрчлөлт No:03	Хуудас: 1/3
	Өөрчлөлтийн огноо:25.04.2024	

4 Итгэмжлэлийн хүрээ

MNAS нь Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын итгэмжлэлийн хүрээг ISO 22003-1 стандартын А.1 хүснэгтэд тулгуурлан тодорхойлно.

5 Баталгаажуулалтын байгууллага (ББ)-ын чадамж

MNAS-н итгэмжлэл нь тухайн баталгаажуулалтын байгууллага техникийн кластерийн хүрээнд ISO 22000 Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтыг хийх чадвартайг харуулна. Баталгаажуулалтын байгууллага нь итгэмжлэлийн хамрах хүрээгээ тодорхойлж, тухайн хүрээнд баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулах чадвартайгаа батлах үүрэгтэй.

Баталгаажуулалтын байгууллага аудитор, шинжээчдийнхээ анхдагч үнэлгээ, ур чадвар, гүйцэтгэл, мониторингийн талаар ISO/IEC 17021, ISO 22003-1 болон ISO 19011 стандартад үндэслэсэн журамтай байна. Баталгаажуулалтын байгууллага нь техникийн тодорхой кластерт аудитор / шинжээч бэлтгэх журамтай байна.

6 Баталгаажуулалтын байгууллагын Аудит хийх хугацаа

Баталгаажуулалтын байгууллага нь ISO 22003-1 стандартын В.1 хүснэгтийн заалтуудын дагуу аудитын үйл ажиллагааны өсөлт/бууралтын дагуу аудит явуулахад шаардлагатай хүн өдрийг тухайн салбар, кластер эсхүл норматив баримт бичгийн ялгаанд үндэслэн тогтооно.

---xxx---

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC11	Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо:18.12.2015	Өөрчлөлт No:03	Хуудас: 2/3
	Өөрчлөлтийн огноо:25.04.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ

Өөрчлөлтийн бүртгэл

Өөрчлөлт №.	Огноо	Баталсан	Гарсан өөрчлөлт
01	2021.01.20	MNAS дарга	MNAS-д өөрчлөлт гарсан тул жижиг өөрчлөлтүүд хийв.
02	2022.11.17	MNAS дарга	Шинэчлэгдсэн ISO 22003-1:2022 стандартад нийцүүлэв
03	2024.04.25	MNAS дарга	Дахин хянаж, MNAS-д гарсан өөрчлөлтийн дагуу шинээр батлав.

ҮНДЭСНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТӨВ		
Баримт бичгийн No: MNAS AC11	Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын байгууллагын итгэмжлэлийн шалгуур	
Хэвлэсэн огноо:18.12.2015	Өөрчлөлт No:03	Хуудас: 3/3
	Өөрчлөлтийн огноо:25.04.2024	

ЦАХИМ ХУВЬ. ЦАХИМААС ХЭВЛЭСЭН ХУВЬ НЬ ХЯНАЛТГҮЙ ХУВЬ